

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

**АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын
нэр:

*Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн
тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх*

Тендер шалгаруулалтын
дугаар:

МРЦМ/20240101332

Улаанбаатар хот

2024 он

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА	6
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	16
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	21
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	29
V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ	30
VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ.....	34

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-г зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1.Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3.ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3.Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1.Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт

бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд 14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал 15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг 16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг

тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний

хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн

22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Давуу эрх олгох

31.1. Захиалагч нь хуулийн 8.4, 8.7-д зааснаар давуу эрх олгоход оролцогчийн ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу үнийг хийсвэрээр бууруулж тооцно.

31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

33.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

33.1.2. ТШЗ-ны 21.5-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;

- 33.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
 - 33.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
 - 33.1.5. ТШЗ-ны 31.1-д зааснаар давуу эрх олгох;
 - 33.1.6. ТШЗ-ны 32.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 33.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
- 33.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
 - 33.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 35-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
 - 33.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 33.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 33.4. ТШЗ-ны 33.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх** 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах** 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны

19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

35.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Мэдэгдэл хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Урьдчилгаа төлбөр** 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 39.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 39.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.
- 39.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: МРЦМ/20240101332/01
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц № 1: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх-Галтын талбай (XV-020521)-Алт Багц № 2: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх-Хашаат овоот даваат (XV-020580)-Алт Багц № 3: Зүүн цагаан дэл (MV-011722) талбайд геологи хайгуулын өрөмдлөг, технологийн судалгаа, үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх (нөөцийн зэрэглэл ахиулах)
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Захиалагч өөрийн хөрөнгөөр
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 2,573,586,600.00 төгрөг Багц №1: 362,500,000.00 төгрөг Багц №2: 1,712,750,000.00 төгрөг Багц №3: 498,336,600.00 төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Монголросцветмет ТӨҮГ Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-98, “Монголросцветмет” ТӨҮГ Утасны дугаар: 11-450060 Цахим шуудангийн хаяг: mailbox@monros.mn Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлт гаргахдаа “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.3.4-т заасны дагуу www.tender.gov.mn-д тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргах бөгөөд утсаар тодруулга, мэдээлэл өгөх боломжгүй болно.
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	

ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй” .
ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <p><i>Тендерт оролцогч дараах нөхцлүүдийн аль нэг нь үүсээгүй тухай мэдэгдлийг бичгээр гаргана. Үүнд:</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөлд байгаа; 2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй; 3. Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн; 4. Тухайн тендер шалгаруулалтад оролцоходоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон; 5. Захиалагчаас хараат этгээд эсэх; 6. Тендерт оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд, оролцогч компанийн эрх бүхий албан тушаалтны аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон; 7. Тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай; 8. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй; 9. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд.
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан /багцын/ төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх. - Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ төсөвт өртгийн /багцийн/ 30 хувиас багагүй байх. - Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй байх - Сүүлийн хоёр жилийн буюу 2022, 2023 оны хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан; - Сүүлийн хоёр жил буюу 2022, 2023 оны хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.

	<ul style="list-style-type: none"> - Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт. 																				
<p>ТШЗ 18.2</p>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p><i>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 оны жилийн тайлан.</i></p> <ul style="list-style-type: none"> - Сүүлийн хоёр жил буюу 2022, 2023 оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт - харилцагч банкны мэдэгдэл; - Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа; - сүүлийн гурван жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл. 																				
<p>ТШЗ 19.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”</p> <p><i>Хэрэв шаардах бол уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бичих]</i></p> <p><i>Геологи хайгуулын ажил гүйцэтгэх, нөөцийн тооцоо хийх чадвартай боловсон хүчинтэй байх, үүнээс геологич нь мэргэшсэн зэргээс дээш зэрэгтэй байх</i></p> <p><i>Зөвлөхийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод төвшин:</i></p> <table border="1" data-bbox="464 1122 1498 1525"> <thead> <tr> <th>Д/д</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Мэргэш ил</th> <th>Ажлын туршлага</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Геологич (Геологи хайгуулын ажлыг удирдах, технологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэх, түүний дүнгээр нөөцийн тайлан боловсруулах)</td> <td>1</td> <td>Зөвлөх</td> <td>5-аас дээш жил ажилласан байх</td> </tr> <tr> <td>2</td> <td>Геологич (Геологи хайгуулын ажил, технологийн судалгааны ажлыг гардан гүйцэтгэх)</td> <td>2</td> <td>Мэргэшсэн</td> <td>5-аас дээш жил ажилласан байх</td> </tr> <tr> <td>3</td> <td>Геологи- хайгуулын өрмийн ажлын инженер (заагдсан хайгуулын өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэх)</td> <td>2</td> <td>Инженер</td> <td>5-аас дээш жил ажилласан байх</td> </tr> </tbody> </table> <p>Нотлох баримт:</p> <ul style="list-style-type: none"> - Голлох инженерүүдийн төгссөн сургуулийн диплом, (зөвлөх, мэргэшсэн инженерийн гэрчилгээ), нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг ирүүлнэ. - Үндсэн мэргэжлийн ажиллагсад болон гэрээт ажиллагсадын гэрээний хувь, мэргэжлийн үнэмлэхийг хуулбарлан ирүүлнэ. Дээрх баримт бичгийг PDF хэлбэрт шилжүүлэн цахимаар ирүүлнэ. <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> 1. Геологи хайгуулын өрмийн машин 2. Усны цистерн 3. Үйлчилгээний тээврийн хэрэгсэл 4. Бусад шаардлагатай багаж/хэмжих/турших хэрэгслүүд 	Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэш ил	Ажлын туршлага	1	Геологич (Геологи хайгуулын ажлыг удирдах, технологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэх, түүний дүнгээр нөөцийн тайлан боловсруулах)	1	Зөвлөх	5-аас дээш жил ажилласан байх	2	Геологич (Геологи хайгуулын ажил, технологийн судалгааны ажлыг гардан гүйцэтгэх)	2	Мэргэшсэн	5-аас дээш жил ажилласан байх	3	Геологи- хайгуулын өрмийн ажлын инженер (заагдсан хайгуулын өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэх)	2	Инженер	5-аас дээш жил ажилласан байх
Д/д	Албан тушаал	Хүний тоо	Мэргэш ил	Ажлын туршлага																	
1	Геологич (Геологи хайгуулын ажлыг удирдах, технологийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэх, түүний дүнгээр нөөцийн тайлан боловсруулах)	1	Зөвлөх	5-аас дээш жил ажилласан байх																	
2	Геологич (Геологи хайгуулын ажил, технологийн судалгааны ажлыг гардан гүйцэтгэх)	2	Мэргэшсэн	5-аас дээш жил ажилласан байх																	
3	Геологи- хайгуулын өрмийн ажлын инженер (заагдсан хайгуулын өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэх)	2	Инженер	5-аас дээш жил ажилласан байх																	

	<p><i>Дээр дурдсан машин механизм нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийн эсвэл түрээсийн байж болно. Түрээсийн машин тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд түрээслүүлэгчтэй машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зүйлд нийцүүлэн хийсэн байх бөгөөд дуусах хугацаа нь ажил гүйцэтгэж дуусах хугацаа хүртэл хүчинтэй байна.</i></p> <p><i>Машин тоног төхөөрөмж нь тендерт оролцогчин эсхүл түрээсийн болохыг дараах бичиг баримтаар нотлоно. Үүнд:</i></p> <ol style="list-style-type: none"> <i>1. Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар</i> <i>2. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн түрээсийн гэрээ</i> <p><i>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”.</i></p> <p><i>Батлагдсан төсөвт /багцын/ өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг 2021 2022, 2023 онуудын хугацаанд доод тал нь 1-ээс доошгүй удаа байх.</i></p> <p><i>Ижил төстэй ажил гэж “Геологи хайгуулын өрөмдлөг, геологи хайгуулын ажил болон ГХА-ын дүнгээр нөөцийн тайлан боловсруулсан ажил”-ыг ойлгоно.</i></p> <p><i>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</i></p> <p><i>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гарээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 5-ын дагуу бэлтгэж ирүүлнэ.</i></p> <p><i>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”</i></p> <ul style="list-style-type: none"> <i>- Геологи хайгуулын ажил, нөөцийн тайлан боловсруулах чиглэлийн ажил гүйцэтгэсэн туршлага: 3 жилээс багагүй байх</i> <i>- Ажил гүйцэтгэхэд ашиглах шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй байх</i> <i>- Хайгуулын ажил болон бусад ажилд ашиглах багаж, хэрэгслэлүүд нь тогтоогдсон тохируулга, магадалгаа хийгдсэн, батламжтай байх</i>
ТШЗ 19.2	<p><i>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</i></p> <ul style="list-style-type: none"> <i>- Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх;</i> <i>- 2021, 2022, 2023 онд ижил төстэй хийж гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 4, 6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл;</i> <i>- Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшлийн, түрээслэх гэх мэт);</i> <i>- Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт.</i>
ТШЗ 19.3	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардахгүй”
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: Төсөвт өртөг /багц/-ийн 0.5% тэнцүү буюу Багц №1: 1,812,500.00 төгрөг;

	Багц №2: 8,563,750.00 төгрөг. Багц №3: 2,491,683.00 төгрөг
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 2. Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн итгэмжлэл 3. Тусгай зөвшөөрөл- шаардахгүй 4. НӨАТ төлөгчийн гэрчилгээ 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /цахим/ 6. Харилцагч банк, татварын алба, нийгмийн даатгалын байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл <p>Жич: Бүдэг харагдахгүй болон ойлгомжгүй баримт бичиг ирүүлсэн тохиолдолд тус тендерийн материалыг хүчингүйд тооцно. Тендерийн хэлнээс өөр хэлээр ирүүлэх материалыг орчуулгын хамт ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь нууцалж ирүүлнэ. /цахим хэлбэрээр/</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 05 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, “Монголросцветмет” ТӨҮГ</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	<p>Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:</p> <p>Шаардахгүй.</p>
ТШЗ 32.1	<p>Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”</p>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 37.1	<p>Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм”</p> <p>Тендерт шалгарч, гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нийт төсөвт өртгийн 3 хувиар тооцож, хуулийн 42.3-т заасан хэлбэрээр гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</p>
Ё. БУСАД	
ТШЗ 38.1	<p>Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”</p>

Ш БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Тендер шалгаруулалтын нэр: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/20240101332

Багц № 1: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх-Галтын талбай (XV-020521)-Алт

Төсөвт өртөг: 362.5 сая төгрөг

Багц № 2: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх-Хашаат овоот даваат (XV-020580)-Алт

Төсөвт өртөг: 1712.75 сая төгрөг

Багц № 3: Зүүн цагаан дэл (MV-011722) талбайд геологи хайгуулын өрөмдлөг, технологийн судалгаа, үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх (нөөцийн зэрэглэл ахиулах)

Төсөвт өртөг: 498.3366 сая төгрөг

Багц № 1: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх-Галтын талбай (XV-020521)-Алт

ХҮ-020521 тоот “Галтын талбай” нэртэй талбайд 2024 онд хийгдэх геологи хайгуулын ажлын даалгавар

Судалгааны үе шат	“Монголросцветмет” ТӨҮГ-ын Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020521 тоот “Галтын талбай” нэртэй талбайд геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх
Судалгаа явуулах хугацаа:	Эхлэх хугацаа: 2024 оны 3-р улиралд Дуусах хугацаа: Гэрээний хүчинтэй хугацаанд
Судалгааны талбайн нэр:	Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020521 тоот тусгай зөвшөөрөлтэй Галтын талбай нэртэй хайгуулын талбай.
Судалгааны талбайн солбицол:	104° 25' 25.91" 48° 10' 49.82" Төв аймгийн Заамар сумын Өгөөмөр тосгоны төвөөс урд зүгт 10 км.
Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	“Монголросцветмет” ТӨҮГ, өөрийн хөрөнгөөр
Захиалагч байгууллага:	“Монголросцветмет” ТӨҮГ

1. Ажлын даалгавар өгөх үндэслэл	“Монголросцветмет” ТӨҮГ-ын Бизнес төлөвлөгөө, 2024 оны худалдан авалтын төлөвлөгөө, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Геологи хайгуулын төлөвлөгөө
2. Ажлын зорилго, гарах үр дүн	-Тус талбайн хүрээнд өмнөх онуудад хийгдсэн геологи хайгуулын ажлын үеийн мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээлэлийг боловсруулан судалж, цаашид тухайн талбайд ямар шатны хайгуулын ажлыг хэрхэн хийх тухай дүгнэлт гаргах. -Геологи хайгуулын ажлын хэмжээг тооцоолох, хайгуулын торын нягтралыг оновчлох, хайгуулын өрөмдлөг хийх. - Өрөмдлөгийн үр дүнгээр алтны хуримтлал үүссэн талбайг ялгах, хурдас хуримтлалын зузаан, агуулгыг тодорхойлох. - Хайгуулын ажлын үр дүнд үндэслэн ордын нөөцийг бодитой /В/, боломжтой /С/ зэрэгт шилжүүлэн, үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулахад оршино.
3. Судалгааны ажлын хөтөлбөр:	Геологи хайгуулын ажлын хүрээнд зайлшгүй хийж гүйцэтгэх ажлууд /гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй/:

	<ul style="list-style-type: none"> - Өмнөх судалгааны ажлуудыг судлах, өрөмдлөг хийх шугам, цооногийн байршлыг сонгох - Геологи хайгуулын болон тандан судалгааны өрөмдлөг, - Цооногийн бичиглэл, дээжлэлтийн ажлууд - Суурин боловсруулалт - Үр дүнд үндэслэн үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулах.
<p>4. Судалгааны ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал:</p>	<p><u>Хээрийн бэлтгэл ажил:</u></p> <ul style="list-style-type: none"> - Тухайн талбайн хэмжээнд өмнө хийгдсэн геологийн материалуудтай нэг бүрчлэн танилцах, цаашид хийгдэх хайгуулын ажлын арга зүй, аргачлалыг нарийвчлан боловсруулах. - Өрөмдлөг хийх шугам, цооногуудыг төлөвлөн тухайн жил бүрийнхээ хайгуулын ажлын ТӨҮГ-т танилцуулж АМГТГ болон хяналтын байгууллагаар батлуулах, - Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг тухайн жил бүртээ Төв аймгийн Заамар сумын Засаг дарга, БОХУБайцаагчаар батлуулах, байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байршуулах, төлөвлөгөөг Төв аймгийн БОАЖГ-т танилцуулах. - Хайгуулын талбайд геологи хайгуулын ажилд шаардагдах тоног төхөөрөмжийг тээвэрлэн аваачих, ажилчдын кемп байгуулан ажилд бэлэн болгох - Дээрх ажлуудыг гүйцэтгэн төлөвлөлтийг “Монголросцветмет” ТӨҮГ-ын холбогдох албан тушаалтанд танилцуулан баталгаажуулах, хамтарсан хурлын тэмдэглэл үйлдэж актаар баталгаажуулах. <p><u>Хээрийн судалгааны үе:</u></p> <ul style="list-style-type: none"> - “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Шижир алт АҮ-ийн ХАБЭА-н журам, заавартай танилцаж, ажиллах зөвшөөрөл авах. - Судалгааны ажлыг хийхдээ геологийн маршрут, геоморфологи, геологийн тогтоц, гидрогеологийн байгалийн суурь нөхцөлтэй газар дээр нь нарийвчлан танилцах, - Анхан шатны мэдээлэл, баримтыг цуглуулан, агаар сансрын зурагт тайлан боловсруулалтыг хийж, геологийн шалгуур үзүүлэлтүүд, шинж тэмдгүүдийг илрүүлэх. - Судалгааны талбайн геологийн тогтоц, гидрогеологийн нөхцөлийг иж бүрэн үнэлж, хайгуулын арга, аргачлалын дагуу цооног өрөмдлөгийн ажил явуулах, - Хайгуулын торын нягтрал нь 200х20м буюу ордын нөөцийг бодитой /В/, боломжтой /С/ зэргээр тооцох хэмжээний шаардлага хангасан байна. - Хайгуулын талбайн хэмжээнд тус бүр ул чулуулаг илрэх хүртэл гүнтэй цооног, нийт 1000 т.м өрөмдлөгийн ажлыг технологийн дагуу өрөмдөх, - Цооногийн дээжлэлтийг зохих журмын дагуу явуулах, хяналтын дээжлэлт хийх, цооногийн холболт хэмжилтийг ажил гүйцэтгэсэн хэсгүүдийг бүрэн хамруулан энэ чиглэлийн эрх бүхий байгууллагаар 200 га-д гүйцэтгүүлэх, - Геологи хайгуулын ажил, өрөмдлөг хийгдсэн талбайн нөхөн сэргээлтийг хийж, сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх, маягт №7-оор баталгаажуулах. - Хээрийн ажлын үеийн өрөмдлөгийн журнал болон дээжлэлт, туршилтын ажлын анхдагч материалуудыг зохих журмын дагуу хүлээлгэн өгөх гэх мэт. <p>Суурин боловсруулалтын үе:</p>

	- Геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан боловсруулах, хэрэв ашигт малтмалын нөөц тогтоогдсон бол ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулах.
5. Мөрдөх хууль тогтоомж, стандарт, журам, эрх зүйн баримт бичгүүд:	-Ашигт малтмалын тухай хууль; -Байгаль орчныг хамгаалах тухай хууль; -Уул уурхайн сайдын 2015 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Ангилал, заавар батлах тухай”, -Бусад холбогдох журам, норм, стандартууд
6. Тавигдах шаардлага, тусгай нөхцөл	-Тайлан, зөвлөмжийн бичиг баримт /DWG, PDF file болон Word, Excel зэрэг бүхий л электрон хэлбэрээр/ нь Захиалагчийн өмч болох ба түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. -Геологи хайгуулын ажил хийх аж ахуйн нэгж, байгууллага нь шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин, мэргэжлийн багаж тоног төхөөрөмж, өрмийн машинаар хангагдсан байна. -Ашиглаж байгаа багаж, хэрэгслэлүүд нь тогтоогдсон тохируулга, магадалгаа хийгдсэн, батламжтай байна. -Хайгуул судалгааны ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжүүдийн бичиг баримтын бүрдүүлэлт бичвэр нь олон улс болон Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, дүрэм журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ. -Гүйцэтгэгч нь зохих шатны хяналтын байгуулагуудад танилцуулах, зөвшилцөх шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлэх ба үүнд гарах зардлыг дангаар хариуцна. - Гүйцэтгэгч нь хайгуулын ажлын жилийн тайлангуудыг дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор илгээн АМГТГ-т баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ. -Тайланд тусгагдах техникийн болон бусад аливаа шийдлүүдийг судалгааны ажлын явцад Захиалагчтай зөвшилцөх ба хамтарсан уулзалтын тэмдэглэлээр баталгаажуулна.
7. Хавсралт мэдээлэл	- Шаардлагатай мэдээллийг гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагчтай зөвшилцөн авч болно.

Багц № 2: Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх-Хашаат овоот даваат (XV-020580)-Алт

ХҮ-020580 тоот “Хашаат Овоот Даваат” нэртэй талбайд 2024 онд хийгдэх геологи хайгуулын ажлын даалгавар

Судалгааны үе шат	“Монголросцветмет” ТӨҮГ-ын Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020580 тоот “Хашаат Овоот Даваат” нэртэй хайгуулын талбайн Хашаатын хөндийд геологи хайгуулын ажил гүйцэтгэх
Судалгаа явуулах хугацаа:	Эхлэх хугацаа: 2024 оны 3-р улиралд Дуусах хугацаа: Гэрээний хүчинтэй хугацаанд
Судалгааны талбайн нэр:	Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020580 тоот тусгай зөвшөөрөлтэй Хашаат Овоот Даваат нэртэй хайгуулын талбайн Хашаатын хөндий.
Судалгааны талбайн солбицол:	Төв аймгийн Заамар сумын Өгөөмөр тосгоны төвөөс зүүн урд зүгт 30 км
Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	“Монголросцветмет” ТӨҮГ, өөрийн хөрөнгөөр
Захиалагч байгууллага:	“Монголросцветмет” ТӨҮГ

<p>8. Ажлын даалгавар өгөх үндэслэл</p>	<p>“Монголросцветмет” ТӨҮГ-ын Бизнес төлөвлөгөө, 2024 оны худалдан авалтын төлөвлөгөө, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Геологи хайгуулын төлөвлөгөө</p>
<p>9. Ажлын зорилго, гарах үр дүн</p>	<p>-Тус талбайн хүрээнд өмнөх онуудад хийгдсэн геологи хайгуулын ажлын үеийн мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээлэлийг боловсруулан судалж, цаашид тухайн талбайд ямар шатны хайгуулын ажлыг хэрхэн хийх тухай дүгнэлт гаргах.</p> <p>-Геологи хайгуулын ажлын хэмжээг тооцоолох, хайгуулын торын нягтралыг оновчлох, хайгуулын өрөмдлөг хийх.</p> <p>- Өрөмдлөгийн үр дүнгээр алтны хуримтлал үүссэн талбайг ялгах, хурдас хуримтлалын зузаан, агуулгыг тодорхойлох.</p> <p>- Эдгээрт үндэслэн урьдчилсан эдийн засгийн үр ашгийн тооцоо хийж дүгнэлт гаргах, үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулах,</p>
<p>10. Судалгааны ажлын хөтөлбөр:</p>	<p>Геологи хайгуулын ажлын хүрээнд зайлшгүй хийж гүйцэтгэх ажлууд /гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй/:</p> <ul style="list-style-type: none"> - Өмнөх судалгааны ажлуудыг судлах, өрөмдлөг хийх шугам, цооногийн байршлыг сонгох - Геологи хайгуулын болон тандан судалгааны өрөмдлөг, - Цооногийн бичиглэл, дээжлэлтийн ажлууд - Суурин боловсруулалт - Үр дүнд үндэслэн үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулах,
<p>11. Судалгааны ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал:</p>	<p><i>Хээрийн бэлтгэл ажил:</i></p> <ul style="list-style-type: none"> - Тухайн талбайн хэмжээнд өмнө хийгдсэн геологийн материалуудтай нэг бүрчлэн танилцах, цаашид хийгдэх хайгуулын ажлын арга зүй, аргачлалыг нарийвчлан боловсруулах. - Өрөмдлөг хийх шугам, цооногуудыг төлөвлөн тухайн жил бүрийнхээ хайгуулын ажлын төлөвлөгөөг ТӨҮГ-т танилцуулж АМГТГ болон хяналтын байгууллагаар батлуулах, - Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг тухайн жил бүртээ Төв аймгийн Заамар сумын Засаг дарга, БОХУБайцаагчаар батлуулах, байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байршуулах, төлөвлөгөөг Төв аймгийн БОАЖГ-т танилцуулах. - Хайгуулын талбайд геологи хайгуулын ажилд шаардагдах тоног төхөөрөмжийг тээвэрлэн аваачих, ажилчдын кемп байгуулан ажилд бэлэн болгох - Дээрх ажлуудыг гүйцэтгэн төлөвлөлтийг “Монголросцветмет” ТӨҮГ-ын холбогдох албан тушаалтанд танилцуулан баталгаажуулах, хамтарсан хурлын тэмдэглэл үйлдэж актаар баталгаажуулах. <p><i>Хээрийн судалгааны үе:</i></p> <ul style="list-style-type: none"> - “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Шижир алт АҮ-ийн ХАБЭА-н журам, заавартай танилцаж, ажиллах зөвшөөрөл авах. - Анхан шатны мэдээлэл, баримтыг цуглуулан, агаар сансрын зурагт тайлан боловсруулалтыг хийж, геологийн шалгуур үзүүлэлтүүд, шинж тэмдгүүдийг илрүүлэх. - Судалгааны талбайн геологийн тогтоц, гидрогеологийн нөхцөлийг иж бүрэн үнэлж, хайгуулын арга, аргачлалын дагуу цооног өрөмдлөгийн ажил явуулах, - Хайгуулын торын нягтрал нь 200х20м буюу ордын нөөцийг бодитой /В/, боломжтой /С/ зэргээр тооцох хэмжээний шаардлага хангасан байна.

	<p>- Хайгуулын талбайн Хашаат нэртэй хөндийн хэмжээнд тус бүр ул чулуулаг илрэх хүртэл гүнтэй цооног, нийт 6000 т.м өрөмдлөгийн ажлыг технологийн дагуу өрөмдөх,</p> <p>- Тухайн Хашаат хөндийд өрөмдөх шаардлагагүй т.м илүү гарвал бусад хөндийд /Ж нь: Овоот/ шилжүүлэн өрөмдөх</p> <p>- Цооногийн дээжлэлтийг зохих журмын дагуу явуулах, хяналтын дээжлэлт хийх, цооногийн холболт хэмжилтийг ажил гүйцэтгэсэн хэсгүүдийг бүрэн хамруулан энэ чиглэлийн эрх бүхий байгууллагаар 200 га-д гүйцэтгүүлэх,</p> <p>- Геологи хайгуулын ажил, өрөмдлөг хийгдсэн талбайн нөхөн сэргээлтийг хийж, сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх, маягт №7-оор баталгаажуулах.</p> <p>- Хээрийн ажлын үеийн өрөмдлөгийн журнал болон дээжлэлт, туршилтын ажлын анхдагч материалуудыг зохих журмын дагуу хүлээлгэн өгөх гэх мэт.</p> <p>Суурин боловсруулалтын үе:</p> <p>- Геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан боловсруулах, хэрэв ашигт малтмалын нөөц тогтоогдсон бол ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулах,</p>
<p>12. Мөрдөх хууль тогтоомж, стандарт, журам, эрх зүйн баримт бичгүүд:</p>	<p>-Ашигт малтмалын тухай хууль;</p> <p>-Байгаль орчныг хамгаалах тухай хууль;</p> <p>-Уул уурхайн сайдын 2015 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Ангилал, заавар батлах тухай”,</p> <p>-Бусад холбогдох журам, норм, стандартууд</p>
<p>13. Тавигдах шаардлага, тусгай нөхцөл</p>	<p>-Тайлан, зөвлөмжийн бичиг баримт /DWG, PDF file болон Word, Excel зэрэг бүхий л электрон хэлбэрээр/ нь Захиалагчийн өмч болох ба түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.</p> <p>-Геологи хайгуулын ажил хийх аж ахуйн нэгж, байгууллага нь шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин, мэргэжлийн багаж тоног төхөөрөмж, өрмийн машинаар хангагдсан байна.</p> <p>-Хайгуул судалгааны ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжүүдийн бичиг баримтын бүрдүүлэлт бичвэр нь олон улс болон Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, дүрэм журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.</p> <p>-Гүйцэтгэгч нь зохих шатны хяналтын байгууллагуудад танилцуулах, зөвшилцөх шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлэх ба үүнд гарах зардлыг дангаар хариуцна.</p> <p>- Гүйцэтгэгч нь хайгуулын ажлын жилийн тайлангуудыг дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор илгээн АМГТГ-т баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>-Тайланд тусгагдах техникийн болон бусад аливаа шийдлүүдийг судалгааны ажлын явцад Захиалагчтай зөвшилцөх ба хамтарсан уулзалтын тэмдэглэлээр баталгаажуулна.</p> <p>- Ордын нөөцийн тооцоотой тайланд томилогдсон шинжээчийн гэрээг “Монголросцветмет ТӨҮГ байгуулах ба тайлан хэлэлцүүлэхтэй холбоотой бусад бүхий л зардлыг Гүйцэтгэгч хариуцна.</p>
<p>14. Хавсралт мэдээлэл</p>	<p>- Шаардлагатай мэдээллийг гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагчтай зөвшилцөн авч болно.</p>

Багц № 3: Зүүн цагаан дэл (MV-011722) талбайд геологи хайгуулын өрөмдлөг, технологийн судалгаа, үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх (нөөцийн зэрэглэл ахиулах)

MV-011722 тоот “Зүүн цагаан дэл” ордод 2024 онд гүйцэтгэх Геологи хайгуулын ажлын даалгавар

Судалгааны үе шат	“Монголросцветмет” ТӨҮГ-ын Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших MV-011722 тоот “Зүүн цагаан дэл” ордод геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх
Судалгаа явуулах хугацаа:	Эхлэх хугацаа: Гэрээ байгуулснаас хойш 15 хоног Дуусах хугацаа: Гэрээний хүчинтэй хугацаанд
Судалгааны талбайн нэр:	Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших MV-011722 тоот “Зүүн цагаан дэл” орд
Судалгааны талбайн солбицол:	Дорноговь аймгийн Иххэт сумаас хойд зүгт 10км, Бор-Өндөр сумын төвөөс зүүн урд зүгт 60 км
Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	“Монголросцветмет” ТӨҮГ, өөрийн хөрөнгөөр
Захиалагч байгууллага:	“Монголросцветмет” ТӨҮГ

15. Ажлын даалгавар өгөх үндэслэл	“Монголросцветмет” ТӨҮГ-ын Бизнес төлөвлөгөө, 2024 оны худалдан авалтын төлөвлөгөө “Монголросцветмет” ТӨҮГ-ын Геологи хайгуулын төлөвлөгөө
16. Ажлын зорилго, гарах үр дүн	-Тус талбайд 1976-1978 онуудад хийгдсэн нарийвчилсан хайгуулын үр дүнгийн тайлан болон ашиглалтын үеийн мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээлэлийг боловсруулан судалж, цаашид тухайн талбайд ямар шатны хайгуулын ажлыг хэрхэн хийх тухай дүгнэлт гаргах. -Геологи хайгуулын ажлын хэмжээг тооцоолох, нөөцийг бодитой /В/, боломжтой /С/ зэрэгт шилжүүлэхээр тооцож хайгуулын торын нягтралыг оновчлох, хайгуулын өрөмдлөг хийх. - Хайгуулын ажлын үр дүнд үндэслэн ордын нөөцийг бодитой /В/, боломжтой /С/ зэрэгт шилжүүлэн, үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулахад оршино.
17. Судалгааны ажлын хөтөлбөр:	Геологи хайгуулын ажлын хүрээнд зайлшгүй хийж гүйцэтгэх ажлууд /гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй/: - Өмнөх судалгааны ажлуудыг судлах, өрөмдлөг хийх шугам, цооногийн байршлыг сонгох - Геологи хайгуулын өрөмдлөг, - Цооногийн бичиглэл, дээжлэлтийн ажлууд - Суурин боловсруулалт - Технологийн туршилт хийлгэх - Үр дүнд үндэслэн үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулах.
18. Судалгааны ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал:	Хээрийн бэлтгэл ажил: - Тухайн ордын хэмжээнд өмнө хийгдсэн геологийн болон ашиглалтын үеийн материалуудтай танилцах, цаашид хийгдэх хайгуулын ажлын арга зүй, аргачлалыг нарийвчлан боловсруулах. - Өрөмдлөг хийх шугам, цооногуудыг төлөвлөн 2024 оны хайгуулын ажлын төлөвлөгөөг ТӨҮГ-т танилцуулж АМГТГ болон хяналтын байгууллагаар батлуулах, - Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг дарга, БОХУБайцаагчаар батлуулах, байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг төлөвлөгөөнд тусгагдсаны

	<p>дагуу байршуулах, төлөвлөгөөг Дорноговь аймгийн БОАЖГ-т танилцуулах.</p> <ul style="list-style-type: none"> - Археологи, палеонтологийн судалгаа хийлгэх - Хайгуулын талбайд геологи хайгуулын ажилд шаардагдах тоног төхөөрөмжийг тээвэрлэн аваачих, ажилчдын кемп байгуулан ажилд бэлэн болгох - Дээрх ажлуудыг гүйцэтгэн төлөвлөлтийг “Монголросцветмет” ТӨҮГ-ын холбогдох албан тушаалтанд танилцуулан баталгаажуулах, хамтарсан хурлын тэмдэглэл үйлдэж актаар баталгаажуулах. <p>Хээрийн судалгааны үе:</p> <ul style="list-style-type: none"> - “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБҮ-ийн “Зүүн цагаан дэл” хэсгийн ХАБЭА-н журам, заавартай танилцаж, ажиллах зөвшөөрөл авах, ажлыг эхлүүлэх, - Судалгааны ажлыг хийхдээ өмнө нь ил уурхайн аргаар ашигласан хэсгийн баримт материалыг судлаж, олборлосон нөөцийн хэмжээг гарган балансын тооцоог хийж АМГТГ-аар хянуулах - Хайгуулын ажлын үр дүнгийн тайланд шаардлагатай гэж үзвэл траншей сэргээх, суваг малтах ажил хийж болно. - Уулын малталтын ажлын болон хайгуулын өрөмдлөгийн торын нягтрал нь тухайн ордын нөөцийг бодитой /В/, боломжтой /С/ зэргээр тооцох хэмжээний шаардлага хангасан байна. - Ордын хэмжээнд хайгуулын арга, аргачлалын дагуу нийт 1500 т.м өрөмдлөгийн ажил зэргийг хийж гүйцэтгэх, - Татсан суваг, траншей болон өрөмдсөн цооногуудын хэмжилт, шаардлагатай бичиглэл, баримтжуулалтыг хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар хийлгэх, - Талбайд хийгдэх дээрх ажлуудтай холбоотой дээжлэлтийг зохих журмын дагуу явуулах, технологийн туршилт хийх, геотехникийн судалгаа хийж гүйцэтгэх. - Геологи хайгуулын ажил, өрөмдлөг хийгдсэн талбайн нөхөн сэргээлтийг хийж, сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх, маягт №7-оор баталгаажуулах - Хээрийн ажлын үеийн өрөмдлөгийн журнал болон дээжлэлт, туршилтын ажлын анхдагч материалуудыг зохих журмын дагуу хүлээлгэн өгөх гэх мэт. <p>Суурин боловсруулалтын үе:</p> <ul style="list-style-type: none"> - Геологи хайгуулын ажлын үр дүнгээр нөөцийг бодитой /В/, боломжтой /С/ зэргээр тооцсон нөөцийн тооцоотой тайланг боловсруулан ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, тушаал гаргуулах,
<p>19. Мөрдөх хууль тогтоомж, стандарт, журам, эрх зүйн баримт бичгүүд:</p>	<ul style="list-style-type: none"> -Ашигт малтмалын тухай хууль; -Байгаль орчныг хамгаалах тухай хууль; -Уул уурхайн сайдын 2015 оны 203 дугаар тушаалаар батлагдсан “Ангилал, заавар батлах тухай”, -Бусад холбогдох журам, норм, стандартууд
<p>20. Тавигдах шаардлага, тусгай нөхцөл</p>	<ul style="list-style-type: none"> -Тайлан, зөвлөмжийн бичиг баримт /DWG, PDF file болон Word, Excel зэрэг бүхий л электрон хэлбэрээр/ нь Захиалагчийн өмч болох ба түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. -Геологи хайгуулын ажил хийх аж ахуйн нэгж, байгууллага нь шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин, мэргэжлийн багаж тоног төхөөрөмж, өрмийн машинаар хангагдсан байна.

	<p>-Хайгуул судалгааны ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжүүдийн бичиг баримтын бүрдүүлэлт бичвэр нь Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, дүрэм журмын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.</p> <p>-Гүйцэтгэгч нь зохих шатны хяналтын байгуулагуудад танилцуулах, зөвшилцөх шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлэх ба үүнд гарах зардлыг дангаар хариуцна.</p> <p>- Гүйцэтгэгч нь хайгуулын ажлын жилийн тайлангуудыг дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор илгээн АМГТГ-т баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>-Тайланд тусгагдах техникийн болон бусад аливаа шийдлүүдийг судалгааны ажлын явцад Захиалагчтай зөвшилцөх ба хамтарсан уулзалтын тэмдэглэлээр баталгаажуулна.</p> <p>- Ордын нөөцийн тооцоотой тайланд томилогдсон шинжээчийн гэрээг “Монголросцветмет ТӨҮГ байгуулах ба тайлан хэлэлцүүлэхтэй холбоотой бусад бүхий л зардлыг Гүйцэтгэгч хариуцна.</p>
21. Хавсралт мэдээлэл	- Шаардлагатай мэдээллийг гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагчтай зөвшилцөн авч болно

Зураг төсөл: Захиалагч хайгуулын ажил хийгдэх талбайд өмнө хийгдсэн хайгуулын ажлын материалууд (өөрт байгаа)-ын хуулбарыг гэрээ байгуулсны дараа гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

Шалгалт, туршилт: шаардахгүй

Үе шатны ажлын хуваарь: Тухайн гүйцэтгэх ажлын үе шатны хуваарийг техникийн тодорхойлолт болон гэрээнд заасан үе шатны хуваарийг баримтална. Үүнээс:

Багц №	Талбайн нэр	Эхлэх хугацаа	Дуусгах хугацаа
1	Галтын талбай (XV-020521)	2024 оны 3-р улирлаас	Гэрээний хүчинтэй хугацаанд
2	Хашаат овоот даваат (XV-020580)-	2024 оны 3-р улирлаас	Гэрээний хүчинтэй хугацаанд
3	Зүүн цагаан дэл (MV-011722)	Гэрээ байгуулснаас хойш 15 хоногт	Гэрээний хүчинтэй хугацаанд

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: “Ашиглахгүй”

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас [тоо бичих]-аас илүү [“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих] хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

1. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “Ашиглахгүй”

2. Байгаль орчинд нөлөөлөх байдал: “Ашиглахгүй”

3. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: “Ашиглахгүй”

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1. Тендер илгээх

[огноо]

“Монголросцветмет” ТӨҮГ-т

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [*“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих*]. [*Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих*].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,

эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө]*.

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ
ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Тэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

- Тайлбар
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсэн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- Захиалагчийн нийтлэг үүрэг
- 2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
- 2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
- 2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.
- Захиалагчийн төлөөлөгч
- 2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
- 2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Талбайд нэвтрэх зөвшөөрөл
- 2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
- 2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | |
|---------------------------------------|---|
| Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг | 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө. |
| | 3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө. |
| | 3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна. |
| | 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна. |
| | 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. |
| | 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй. |
| | 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй. |
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч | 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| | 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна. |
| | 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Техникийн болон ажлын талбайн өгөгдөл | 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө. |
| Ажлын талбайн харуул хамгаалалт | 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна. |
| | 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна. |
| Хог, хаягдал ба нөхөн сэргээлт | 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана. |
| | 3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана. |

- 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
- Археологийн болон бусад олдвор 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
- 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.
- Аюулгүй байдал 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- Ажил эхлэх 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-г өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Хугацаа сунгах 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;

- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
- 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- Гэрээний үнэ
 - 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
 - 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
 - 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- Урьдчилгаа төлбөр
 - 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
 - 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.
- Төлбөрийн нөхцөл
 - 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
 - 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
 - 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол

сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

- 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
- 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

Урьдчилгаа баталгаа	төлбөрийн	6.1.	ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.
Гүйцэтгэлийн баталгаа		6.2.	Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.
		6.3.	Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна: 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
		6.4.	Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
		6.5.	ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
		6.6.	Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
Чанарын баталгаа		6.7.	Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.
		6.8.	Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.
		6.9.	ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

- 6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах
 - 7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
 - 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн хүлээх эрсдэл
 - 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
 - 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүнг Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
 - 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
 - 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
 - 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
 - 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- Даатгал
 - 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
 - 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.

- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- | | | |
|------------------------|-----------|---|
| Доголдлыг арилгах | илрүүлэх, | <ul style="list-style-type: none"> 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна. 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө. 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ. 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно. 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө. 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана. |
| Далд доголдол | | <ul style="list-style-type: none"> 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна. |
| Зураг төслийн доголдол | | <ul style="list-style-type: none"> 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна. 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна. |

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- | | |
|-------------------------|---|
| Захиалагч гэрээг цуцлах | <ul style="list-style-type: none"> 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно: <ul style="list-style-type: none"> 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон; |
|-------------------------|---|

- 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
 - 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
 - 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцоходоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
 - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
 - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
 - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
 - 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр

- аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох

- бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх
- 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл
- 10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал
- 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.

- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: <i>Гэрээнд заасны дагуу</i>
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <i>Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан</i>
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <i>Тайланг гэрээ байгуулснаас хойш сар бүрийн 30-ны өдөр</i>
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: <i>“Хийхгүй”</i>
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: <i>“Үгүй”</i> Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <i>0</i>
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: <i>Урьдчилгаа төлбөр олгохгүй</i>
ГЕН 5.6.	<p>Төлбөр төлөх хугацаа: Геологи хайгуулын ажил гүйцэтгэх ажлын даалгавар 4-т заасныг үндэслэн хийгдсэн ажлын төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө.</p> <p>(а) Гэрээний үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх дүнг хээрийн бэлтгэл ажил хийж гүйцэтгэсний дараа төлнө.</p> <p>(б) Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг хээрийн судалгааны үе шатны ажлын 50%-ийг гүйцэтгэсэн тухай актыг үндэслэн төлнө.</p> <p>(в) Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг хээрийн судалгааны үе шатны ажлын үлдэгдэл 50%-ийг гүйцэтгэсэн тухай актыг үндэслэн төлнө.</p> <p>(г) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг суурийн боловсруулалт үе шатны ажил гүйцэтгэсний дараа буюу нөөцийн тайланг ЭБМЗ-р хэлэлцүүлэхэд бэлэн болсоны дараа төлнө. (нөөцийн тайлангийн тойрох хуудас АМГТГ-ын холбогдох мэргэжилтэн нараар гарын үсэг зурагдсаны дараа гэж ойлгоно)</p> <p>(д) Гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх дүнг гэрээ дүгнэсэн акт үйлдсэний дараа төлнө.</p> <p>Ажлыг захиалагчид хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 60 хоногийн дотор холбогдох ажлын гүйцэтгэлийн акт, нэхэмжлэхийг үндэслэн дээр дурдсан хуваарийн дагуу төлнө.</p> <p>Чанарын баталгааны хэмжээ болох гэрээний үнийн дүнгийн 5%-ийг чанарын баталгааны хугацаа дуусмагц төлнө.</p>
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: <i>0</i> Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: <i>ашиглахгүй</i>
ГЕН 6.7.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: <i>“Шаардана.”</i> Чанарын баталгааны хэмжээ: <i>Гэрээний /багцын/ үнийн дүнгийн 5 хувь</i>
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: <i>Гэрээт ажил дууссанаас хойш 6 сар</i>
ГЕН 7.5.	Даатгал: <i>Гүйцэтгэгч гэрээт ажлыг гүйцэтгэн ажиллах ажилтнуудын гэрээ хэрэгжүүлэх хугацаанд эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал болон ажлыг гүйцэтгэхэд ашиглах тээвэр, үйлчилгээ болон өрөмдлөгийн машин, тусгай хэрэгслийг зохих журмын дагуу бүрэн даатгуулна.</i>
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: Хоног тутамд 0.01 хувиар тогтоох ба нийт дүн нь гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: Хоног тутамд 0.01 хувиар тогтоох ба нийт дүн нь гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын үр дүнгээр нөөцийн тооцоотой
тайлан боловсруулж ЭБМЗ-д хэлэлцүүлэх ажлын гэрээ.

Дугаар № МРЦМ/20240101332

..... хот/аймаг

Нэг талаас “Монголросцветмет” ТӨҮГ] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [Гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

- Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
- Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
- Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Гүйцэтгэлийн баталгаа;
 - Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
 - Техникийн тодорхойлолт;
 - Ажил гүйцэтгэх хуваарь.
- Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА